

ЗӨВШӨӨРСӨН:  
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ  
ХӨГЖЛИЙН ЗӨвлӨЛИЙН ДАРГА  
*Ч.Горхижин* Ч.ЭРДЭМБИЛЭГ

БАТЛАВ:  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ  
ДЭРГЭДЭХ СҮРҮЕЭГИЙН  
МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨвлӨЛИЙН  
ДАРГА  
N.НАРАНБАТ



ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН  
“СҮРҮЕЭ СУДЛАЛ”  
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

ИНДЕКС: S(r) 091213

ХУГАЦАА : 1 жил

Улаанбаатар хот  
2022 он

## **БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ :**

Б.Буянхишиг	ЭМЯ-ны дэргэдэх Сүрьеэгийн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны зөвлөх, Анааах ухааны доктор
Р.Оюунгэрэл	Анааахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Халдварт өвчин судлалын тэнхмийн эрхлэгч, Анааах ухааны доктор, дэд профессор
М.Урансайхан	Монголын Сүрьеэтэй Тэмцэх Нийгэмлэгийн сүрьеэгийн эмч

## **ХАМТРАН АЖИЛЛАСАН:**

### **Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлийн төлөөлөл**

Н.Наранбат,	ЭМЯ-ны дэргэдэх Сүрьеэгийн мэргэжлийн салбар зөвлөлийн дарга, Сүрьеэгийн холбооны өрөнхийлөгч, Анааах ухааны доктор, дэд профессор
П.Энхтамир	ЭМЯ-ны дэргэдэх Сүрьеэгийн мэргэжлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн сүрьеэгийн эмч, Анааах ухааны магистр

### **Эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл**

Ж. Баярсайхан	ХӨСҮТ-ийн Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга, Нийгмийн Эрүүл мэндийн магистр
Н.Наранзул	ЭМЯ-ны дэргэдэх Сүрьеэгийн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны тархвар судлаач, Анааах ухааны доктор
Э.Оюунчимэг	ЭМЯ-ны дэргэдэх Сүрьеэгийн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны дарга, Анааах ухааны доктор

## **ХЯНАСАН:**

П.Эрхэмбаяр	Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Нийгмийн эрүүл мэндийн магистр
Б.Туяа	Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Нийгмийн эрүүл мэндийн магистр
Д.Дондогмаа	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны ахлах мэргэжилтэн

Эмнэлгийн мэргэжлийн хөгжлийн  
зөвлөлийн 2022 оны 2-р сарын  
14-р өдрийн 50-р тогтоолоор зөвшөөрөв.

## ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН “СҮРЬЕЭ СУДЛАЛ” ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

### НЭГ. ҮНДЭСЛЭЛ:

Монгол улсын эрүүл мэндийн, түүний дотор халдварт өвчний үеийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд цаашид хаана ажиллахаас үл хамааран сүрьеэ өвчний тусламж, үйлчилгээг орчин үеийн шинжлэх ухааны нотолгоонд суурилан мэргэшлийн өндөр түвшинд үзүүлэх чадамжтай сүрьеэгийн эмч бэлтгэх шаардлагатай байна.

Дэлхий дахинд шинэ болон сэргэн тархаж буй халдварт өвчин тулгамдсан асуудал хэвээр байгаагийн нэг нь сүрьеэ өвчин юм. ДЭМБ-аас Монгол Улсыг 2021 онд Олон Эмэнд Тэсвэртэй Сүрьеэгийн (ОЭТС)-ийн дарамт өндөртэй 30 орны тоонд оруулсан, “Монгол Улсын хүн амын дундах сүрьеэгийн тархалтыг тогтоох судалгааны дүнгээс харахад сүрьеэ өвчний тархалт өмнөх тооцооллоос даруй 3 дахин өндөр байгаа нь сүрьеэгийн байгууллагын хүний нөөцийн дутагдлыг яаралтай нөхөх, цаашид тусламж үйлчилгээг цогцоор үзүүлэх үндсэн мэргэшлийн эмчийг богино хугацаанд бэлтгэх хэрэгцээтэй байна.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн А/447 дугаар “Төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” тушаалаар “Халдварт өвчин судлалын эмч”-ийн үндсэн мэргэшлийн сургалтын чиглэл, индексийг шинэчлэн баталсан ба Эрүүл мэндийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн А/337 дугаар тушаалын 2.5.1.2-т “Хүний их эмчийн бусад үндсэн мэргэшлийн сургалт нь гурваас доошгүй жилийн хугацаатай бөгөөд сургалтын нэг жил нь журмын 2.5.1.1-д заасан ерөнхий мэргэшил судлалын сургалт байна” гэж заасны дагуу энэхүү хөтөлбөрийг 2 жилийн хугацаатайгаар, 2019 оны 6-р сарын 3-ны өдрийн ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтэний хөгжлийн зөвлөлийн 2019 оны 6-р сарын 3-ны өдрийн хурлын №1 тогтоол “Төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлага батлах тухай”, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн А/226 дугаар тушаалаар батлагдсан “Резидент эмчийн ажиллах үлгэрчилсэн журмын шаардлагад нийцүүлэн сүрьеэгийн үндсэн мэргэшлийн 1 жилийн сургалтын хөтөлбөрийг боловсруулав.

### ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн сүрьеэгийн тусламж үйлчилгээг цогцоор үзүүлэх чадамж бүхий сүрьеэс судлалын эмч бэлтгэх

### ГУРАВ. АЛСЫН ХАРАА

**Сүрьеэгийн үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрөөр бэлтгэх эмчийн дүр зураг:** Монгол улсын хүн амд халдварт өвчин түүний дотор сүрьеэгийн үеийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусlamж үйлчилгээг үзүүлэх үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон; сүрьеэ өвчиний оношилгоо, эмчилгээ, сэргийлэлтийг орчин үеийн шинжлэх ухааны нотолгоонд тулгуурлан удирдан зохион байгуулдаг төдийгүй эмнэлгийн бусад мэргэжилтэнүүдэд сүрьеэ өвчиний чиглэлээр зөвлөж, сурган чиглүүлэх, хүн амд сүрьеэгээс сэргийлэх эрүүл мэндийн боловсрол олгох мэдлэг чадвар хандлага эзэмшсэн; эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйг чандлан баримталдаг; багаар манлайлан ажиллах чадвартай, үйлчилүүлэгч үйлчилгээ үзүүлэгчийг холбон сүрьеэ өвчиний тусlamж үйлчилгээг хүн амд чанартай, хүртээмжтэй үзүүлэх чадамжийг эзэмшсэн үндсэн мэргэшлийн эмч байна.

## **ДӨРӨВ. СУРГАЛТЫН ЗОРИЛТ**

Цөм чадамж бүхий сүрьеэ судлалын эмчийг бэлтгэхэд сургалтын зорилт оршино. Үүний тулд дараах дэд чадамжийг эзэмшсэн байна.

1. Сүрьеэ судлалын эмч (Tuberculosis doctor)
2. Мэргэжлийн байх (Professional)
3. Суралцагч (Learner)
4. Харилцагч (Communicator)
5. Хамтрагч (Collaborator)
6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөх (Community Health Advocate)
7. Зохион байгуулагч, манлайлагч (Leader)

### **1. Сүрьеэ судлалын эмч (Tuberculosis doctor)**

- Сүрьеэ өвчинийг илрүүлэх, оношлох, эмчлэх, хянах, сэргийлэх үйл ажиллагааг эмнэлгийн тусlamж үйлчилгээний бүхий л шатанд бие даан хэрэгжүүлэх
- Халдварт өвчин түүний дотор сүрьеэгийн тохиолдол, тархалт дэгдэлт, түүнчлэн Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн тохиолдолд тархвар судлалын анхан шатны сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Сүрьеэ өвчиний чиглэлээр судалгаа шинжилгээ хийх
- Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох
- Халдвартын сэргийлэлт хяналтын дүрмийг мөрдөх
- Ёс суртахууныг эрхэмлэх
- Эмнэлэгийн мэргэжилтэний ёс зүйг сахих

### **2. Мэргэжлийн байх (Professional)**

- Эрүүл мэндийн болон эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх хүсэл эрмэлзлэлтэй, санаачлагатай байх
- Эрүүл мэндийн болон эмнэлгийн тусlamж үйлчилгээний салбарт халдварт өвчин судлалын салбарыг хөгжүүлэх хүсэл эрмэлзлэл, санаачлагатай байх
- Эмнэлгийн бусад мэргэжилтэнүүдэд халдварт өвчиний чиглэлээр зөвлөж сургах

- Хүн амд халдварт өвчнөөс сэргийлэх эрүүл мэндийг боловсрол олгох сургалтыг зохион байгуулах

### **3. Суралцагч (Learner)**

- Хүнлэг энэрэнгүй хандлагыг өдөр тутмын үйл ажиллагаанд дадуулах
- Байгууллагын соёлыг сайжруулахад суралцах
- Мэргэжлийн болон нийгмийн харилцааны чиглэлээр өөрийн түвшинг тодорхойлж өөрөө өөрийгөө хөгжүүлэх хөгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллах
- Шинжлэх ухааны ололт амжилтаас бие даан тасралтгүй суралцаж сүрьеэ өвчин судлалын эмчийн мэдлэг чадвараа нэмэгдүүлэх
- Төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтанд тогтмол хамрагдах
- Мэргэжлийн бүхий үйл ажиллагаандаа халдвартын сэргийлэлт хяналтыг мөрдөх дадалд суралцах
- Бусадтай мэдээлэлээ хуваалцах хандлагад суралцах
- Багийн гишүүдийн амжилт, эерэг хандлагаас суралцах
- Мэргэжлийн алдаанаас зайлсхийхэд суралцах
- Мэргэжлийн шалтгаант ажлаас халшрах хамшинж зэрэг сэтгэлзүйн дарамтаас зайлсхийхэд суралцах

### **4. Харилцагч (Communicator)**

- Нийгмийн харилцаанд хүндлэг энэрэнгүй хандлагаар харилцах
- Үйлчлүүлэгчийн онцлогт тохируулан халдварт өвчний асуудлыг тайлбарлан таниулах
- Багийн гишүүддээ ёс зүйтэй хандах
- Бусдад сэтгэлзүйн зэрэг дэмжлэг үзүүлэх
- Багийн гишүүд болон бусад мэргэшлийн мэргэжилтэнүүдэд халдварт өвчний талаар зөвлөж сургах
- Бусдыг халдвартын сэргийлэлт хяналтын дүрмийг зөрчихөөс сэргийлж анхааруулах

### **5. Хамтрагч (Collaborator)**

- Байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд багийн гишүүдтэй хамтран ажиллах
- Сүрьеэгийн тусlamж үйлчилгээг чанартай зохион байгуулахад төрийн болон төрийн бус байгуулагатай хамтран ажиллах
- Сүрьеэ өвчний асуудлыг багийн гишүүд болон эрүүл мэндийн болон эмнэлгийн бусад мэргэшлийн мэргэжилтэнтэй хамтран шийдвэрлэх
- Сүрьеэгээс сэргийлэлт хяналтыг мөрдөхөд эмнэлгийн бусад мэргэшлийн мэргэжилтэнүүдэд туслах
- Шинжлэх ухааны ололт амжилтыг багийн гишүүд суралцаад хамтран ажиллах
- Сүрьеэгийн үеийн нийгмийн ноцтой байдал үүссэн үе буюу халдварт өвчний дэгдэлт, тахал, цартахлын үед төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийттэй хамтран ажиллах
- Сүрьеэс сэргийлэх чиглэлээр олон нийт, хүн амтай хамтран ажиллах

### **6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөх (Community Health Advocate)**

- Хүн амд сүрьеэ өвчнөөс сэргийлэх эрүүл мэндийн боловсрол олгох
- Хүн амд сүрьеэ өвчний дэгдэлт, тахал, цартахлын үед мөрдөх журмыг тайлбарлан таниулах, зөвлөх
- Үйлчлүүлэгчийн онцлогт тохируулан сүрьеэгийн асуудлыг тайлбарлан таниулах

## 7. Зохион байгуулагч, манлайлагч (Leader)

- Байгуулагын соёлыг сайжруулахад үлгэрлэн ажиллах
- Сүрьеэгийн үеийн тусlamж үйлчилгээг эрүүл мэндийн болон эмнэлгийн тусlamж үйлчилгээний бүхий л шатанд мэргэжлийн үүднээс зохион байгуулах
- Сүрьеэ өвчний тусlamж үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэхэд манлайлан ажиллах
- Хүн амд сүрьеэ өвчнөөс сэргийлэх, сүрьеэ өвчний тухай эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулах

## ТАВ. СУРГАЛТЫН АРГАЗҮЙ

### 5.1 Сургалтын чиглэл, хугацаа, байршил

- Сургалт нь ажлын байрны сургалт(On the job) танхимын (Off the job), хэлбэрээр явагдана.
- Сургалтанд сүрьеэ өвчний эмнэлзүй, сүрьеэгийн тархвар судлал, сүрьеэ өвчний бичил амь судлал, дархлал судлал, лабораторийн оношлогоо, дотрын өвчин судлал түүний дотор хоол боловсруулах эрхтэн судлал, уушги судлал, цус судлал, хавдар судлал, эмнэлзүйн эм судлал гэсэн чиглэлүүдээр тойролт заавал хийж, халдварт өвчний тусlamж үйлчилгээний сургалт болон сонгон суралцах чиглэлээр сургалтанд хамрагдана.
- Сургалтын хугацаа 1 жил байна. Тойролтын хугацааг сургалтын байгууллага өөрийн онцлог, хүчин чадалд тохируулан зохицуулна.
- Сургалт эрхлэх үндсэн байгууллага нь Халдварт Өвчин Судлалын Үндэсний төв, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль байна.
- Аймаг, дүүргийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Хавдар Судлалын Үндэсний төв, Монгол Японы эмнэлэгтэй сүлжээ үүсгэн хамтарч ажиллана.
- Сургалтыг эмнэлгийн тасаг, нэгж, эрчимт эмчилгээ, яаралтай тусlamжийн тасаг, хагалгааны өрөө, амбулатори, тандалтын алба, лаборатори, оношзүйн тасаг, эмнэлзүйн ур чадварын өрөө, сургалтын танхимд зохион байгуулна.

### 5.2 Зайлшгүй танин мэдэж, суралцах шаардлагатай шинж тэмдэг, хам шинж

Сургалтын төгсгөлд цөм чадамж бүхий сүрьеэгийн эмчийг бэлтгэн гаргахын тулд сургагч багшийн хяналтан дор сүрьеэ өвчний үеийн дараах шинж тэмдэг, гардан үйлдлийг үндсэн мэргэшлийн түвшинд бие даан хийж гүйцэтгэх туршлагыг хуримтлуулна.

#### 5.2.1 Шинж тэмдэг (*signs and symptoms*) (эмнэлзүйн тойролтод хамаарах) Үүнд:

1. Хоёр долоон хоногоос дээш ханиалгах (*Coughing for two or more weeks*).

2. Цэр гарах ( *Coughing up blood or mucus*)
3. Амьсгаадах, / *Shortness of breath/*
4. Цээжээр өвдөх, ханиалгах үед, амьсгалах үед цээжээр өвддөг ( *Chest pain, or pain with breathing or coughing*).)
5. Биеийн жин буурах ( *Weight loss*)
6. Ядрах ( *Fatigue*)
7. Халуурах ( *Fever*)
8. Шөнө хөлрөх ( *Night sweats*)
9. Амьсгал, цусны эргэлтийн зогсолт / *Cardiac Arrest /*
10. Ухаан алдалт, баларталт / *Convulsions, Syncope/*
11. Цус алдалт / *Bleeding /*
12. Цустай бөөлжилт / *Vomiting blood /*
13. Шингэн алдалт / *Dehydratase /*
14. Таталт / *Seizures/*
15. Толгой өвдөлт / *Headache /*
16. Дотор муухайралт, бөөлжилт / *Nausea, vomit /*
17. Сэтгэл гутрал / *Depression /*
18. Хавагнах / *Oedema /*
19. Анафилакси / *Anaphylaxis /*
20. Тууралтын хам шинж / *Rash syndrome /*
21. Хордлогын хам шинж / *Poison syndrome/*
22. Тунгалагийн булчирхай томрох (*Enlargement of lymph nodes*)
23. Нурууны өвдөлт (*Back pain*)
24. Сонголын бэрхшээл (*Hearing impairment*)

### **5.2.2 Сүрьеэ өвчин/ Tuberculosis/ A15-A19**

**Бактери судлал ба эд судлалаар батлагдсан амьсгалын эрхтний сүрьеэ (Bacteriologically and cytological confirmed respiratory tuberculosis ) - A15**

1. Бичил шинжлүүрээр зерэг, церний өсгөвөртэй юмуу өсгөвөргүй уушгины сүрьеэ (*Pulmonary tuberculosis, confirmed by smear microscopy or with or without culture*) **A15.0**
2. Зөвхөн өсгөврөөр батлагдсан уушгины сүрьеэ (*Pulmonary tuberculosis, culture-confirmed only*) **A15.1**
3. Эд судлалаар батлагдсан уушгины сүрьеэ (*Pulmonary tuberculosis, histological confirmed*) **A15.2**
4. Тодорхойгүй аргаар баталсан уушгины сүрьеэ (*Pulmonary tuberculosis, confirmed by unspecified method*) **A15.3**
5. Бактери судлал ба эд судлалаар батлагдсан цээжний хөндийн булчирхайн сүрьеэ (*Tuberculosis of intrathoracic lymph nodes, confirmed by bacteriologically and histologically*) **A15.4**
6. Бактери судлал ба эд судлалаар баталсан төвөнх, мөгөөрс, гуурсан хоолойн сүрьеэ (*Tuberculosis of larynx, trachea, and bronchus, confirmed by bacteriologically and histologically*) **A15.5**

7. Бактери судлал ба эд судлалаар баталсан уушгины гялтангийн сүрьеэз (*Tuberculous pleurisy, bacteriological and histological confirmed*) **A15.6**
8. Бактери судлал ба эд судлалаар баталсан амьсгалын замын анхдагч сүрьеэз (*Primary respiratory tuberculosis, confirmed by bacteriologically and histologically*) **A15.7**
9. Бактери судлал ба эд судлалаар баталсан амьсгалын замын бусад сүрьеэз (*Other respiratory tuberculosis, bacteriological and histological confirmed*) **A15.8**
10. Бактери судлал ба эд судлалаар баталсан амьсгалын замын байршил нь тодорхойгүй сүрьеэз (*Respiratory tuberculosis unspecified, confirmed by bacteriologically and histologically*) **A15.9**

**Бактери судлал ба эд судлалаар батлаагүй амьсгалын замын сүрьеэз** (*Respiratory tuberculosis, bacteriological and cytological not confirmed*) - **A16**

1. Бактери судлал ба эд судлалын шинжилгээ сөрөг уушгины сүрьеэз (*Tuberculosis of lung, bacteriology and histology negative*) **A16.0**
2. Бактери судлал ба эд судлалын шинжилгээ хийгээгүй уушгины сүрьеэз (*Tuberculosis of lung, bacteriology, and histology not done*) **A16.1**
3. Бактери судлал ба эд судлалын шинжилгээгээр баталсан эсэх нь тодорхойгүй уушгины сүрьеэз (*Tuberculosis of the lung, without mention of bacteriological, or histological confirmation*) **A16.2**
4. Бактери судлал ба эд судлалын шинжилгээгээр баталсан эсэх нь тодорхойгүй цээжний хөндийн булчирхайн сүрьеэз (*Tuberculosis of intrathoracic lymph nodes, without mention of bacteriological or histological confirmation*) **A16.3**
5. Бактери судлал ба эд судлалын шинжилгээгээр баталсан эсэх нь тодорхойгүй төвөнх, мөгөөрс, гуурсан хоолойн сүрьеэз (*Tuberculosis of larynx and bronchia, without mention bacteriological or histological confirmation*) **A16.4**
6. Бактери судлал ба эд судлалын шинжилгээгээр баталсан эсэх нь тодорхойгүй сүрьеэгийн плеврит (*Tuberculous pleurisy, without mention of bacteriological or histological confirmation*) **A16.5**
7. Бактери судлал ба эд судлалын шинжилгээгээр баталсан эсэх нь тодорхойгүй амьсгалын эрхтний анхдагч сүрьеэз (*Primary respiratory tuberculosis without mention of bacteriological confirmation*) **A16.7**
8. Бактери судлал ба эд судлалын шинжилгээгээр баталсан эсэх нь тодорхойгүй амьсгалын бусад эрхтний сүрьеэз (*Other respiratory tuberculosis, without mention of bacteriological confirmation*) **A16.8**
9. Бактери судлал ба эд судлалын шинжилгээгээр баталсан эсэх нь тодорхойгүй амьсгалын замын байршил нь тодорхойгүй сүрьеэз (*Respiratory tuberculosis unspecified, without mention of bacteriological or histological confirmation*) **A16.9**

**Мэдрэлийн сүрьеэз** (*Tuberculosis of nervous system*) - **A17**

1. Сүрьеэгийн менингит (*Tuberculous meningitis*) **A17.0**
2. Тархины зөөлөн бүрхүүлийн туберкулом (*Meningeal tuberculoma*) **A17.1**
3. Мэдрэлийн тогтолцооны бусад сүрьеэз (*Other tuberculosis of nervous system*) **A17.8**
4. Мэдрэлийн тогтолцооны тодорхойгүй сүрьеэз (*Tuberculosis of nervous system, unspecified*) **A17.9**

### **Бусад эрхтний сүрьеэ (Tuberculosis of other organs) A18**

1. Яс ба үений сүрьеэ (Tuberculosis of bones and joints) **A18.0**
2. Шээс бэлэг эрхтний сүрьеэ (Tuberculosis of the genitourinary system) **A18.1**
3. Сүрьеэгийн гаралтай захын булчирхайн гэмтэл (Tuberculosis peripheral lymphadenopathy) **A18.2**
4. Гэдэс хэвлийн гялтан, чацаархайн тунгалагийн булчирхайн сүрьеэ (Tuberculosis of intestines, peritoneum and mesenteric glands) **A18.3**
5. Арьс ба арьсан доорх эслэгийн сүрьеэ (Tuberculosis of skin and subcutaneous tissue) **A18.4**
6. Нүдний сүрьеэ (Tuberculosis of eye) **A18.5**
7. Чихний сүрьеэ (Tuberculosis of (inner) (middle) ear) **A18.6**
8. Бөөрний дээд булчирхайн сүрьеэ (Tuberculosis of adrenal glands) **A18.7**
9. Бусад эрхтний сүрьеэ (Tuberculosis of other specified organs) **A18.8**

### **Түгмэл сүрьеэ (Miliary tuberculosis) A19**

1. Тодорхой байрлалтай цочмог түгмэл сүрьеэ (Acute miliary tuberculosis of a single specified site) **A19.0**
2. Олон байрлалт цочмог түгмэл сүрьеэ (Acute miliary tuberculosis of multiple sites) **A19.1**
3. Тодорхойгүй байрлалт цочмог түгмэл сүрьеэ (Acute miliary tuberculosis, unspecified) **A19.2**
4. Бусад түгмэл сүрьеэ (Other miliary tuberculosis) **A19.8**
5. Байршил нь тодорхойгүй түгмэл сүрьеэ (Miliary tuberculosis, unspecified) **A19.9**

### **Эмэнд тэсвэртэй сүрьеэ ( Drug resistant tuberculosis with resistance first-line drugs) U82**

1. Нэг ба цөөн эмэнд тэсвэртэй сүрьеэ (Mycobacterium tuberculosis with resistance one or more first-line drugs) **U82.0**
2. Рифампицин тэсвэртэй/Олон эмэнд тэсвэртэй сүрьеэ (Multi-drug resistant tuberculosis (MDR-TB)) **U82.1**

### **Халдварт бус өвчнүүд**

#### **Хавдар (Neoplasms)**

1. Ушгины хорт хавдар (Malignant neoplasms of bronchus and lung) **C34**
2. Төв мэдрэлийн тогтолцоо, тархи, нүдний хорт хавдар (Malignant neoplasms eye, brain and other parts of central nervous system) **C69-C72**
3. Тунгалагийн булчирхайн хорт хавдар (Malignant neoplasms of lymphoid, hematopoietic and related tissue) **C81-C96**
4. Арьсны хорт хавдар (Melanoma and other malignant neoplasms of skin) **C43-C44**

#### **Дотор өвчин судлал**

1. Хоол боловсруулах замын өвчин (Diseases of the digestive system): **K00-K95**
2. Халдвартын бус шалтгаант энтерит ба колит (Noninfective enteritis and colitis) **K50-K52**
3. Элэгний өвчин (Diseases of liver) **K70-K77**
4. Мэдрэлийн тогтолцооны өвчин (Diseases of nervous system) **G00-G99**
5. Чихрийн шижин **E11.9**

**Тойролтын хуваарь (Clinical rotation schedule)**

№	Тойролтын сэдэв	Тойролтын хугацаа /долоо хоногоор/	Сургалт зохион байгуулах газар
1.	Уушгини сүрьеэ, эмэнд тэсвэртэй сүрьеэ	10	Халдварт өвчин судлалын үндэсний төв, дүүргийн эрүүл мэндийн төв
2.	Уушгини бус сүрьеэ	9	Халдварт өвчин судлалын үндэсний төв, дүүргийн эрүүл мэндийн төв
3.	Хүүхдийн сүрьеэ	4	Халдварт өвчин судлалын үндэсний төв
4.	Сүрьеэгийн хяналт, тандалт, сэргийлэлт, нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө	5	Халдварт өвчин судлалын үндэсний төв Анаагахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
5.	Сүрьеэгийн лабораторийн болон радиологийн оношилгоо	4	Халдварт өвчин судлалын үндэсний төв
6.	Яаралтай тусламж, сүрьеэ өвчний үеийн эгзэгтэй байдал	4	Халдварт өвчин судлалын үндэсний төв
7.	Хавдар ( уушгини хавдар, булчирхайн хавдар, хүзүү толгойн хавдар,гэх мэт)	2	Хавдар судлалын үндэсний төв, Аймаг, дүүргийн дүүргийн эрүүл мэндийн төв
8.	Дотрын өвчин( чихрийн шижин, амьсгалын эрхтний эмгэгүүд хodoодны шархлаа, бөөрний дутагдал)	4	Аймаг, дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Монгол Японы эмнэлэг
9.	Сүрьеэгийн үеийн нөхөн сэргээх эмчилгээ	2	Халдварт өвчин судлалын үндэсний төв, Монгол Японы эмнэлэг
<b>Нийт долоон хоног</b>		<b>44</b>	

### Тойролтын агуулга

#### Тойролт 1. Уушгини сүрьеэ, эмэнд тэсвэртэй сүрьеэ

- Нянсудлалаар батлагдсан уушгини сүрьеэгийн эмнэлзүй, оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо, урьдчилан сэргийлэлт
- Эмнэлзүйгээр оношлогдсон сүрьеэ: эмнэлзүй, оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо, урьдчилан сэргийлэлт

- Уушгини эмгэгээс ялган оношилгоо
- Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн хэлбэрүүд, цөөн, рифампицин, олон эмэнд тэсвэртэй
- Эмчилгээний горим, стандарт, богино горим
- Сүрьеэгийн эсрэг эмчилгээний менежмент
- Сүрьеэгийн эсрэг эмийн гаж нөлөө, гаж нөлөөний хяналт
- Хавсарсан эмгэгтэй тохиолдлын эмчилгээ
- Сүрьеэтэй өвчтөнд хийх нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө (Сэтгэл түгшил, сэтгэл гутрал, архины хэрэглээтэй холбоотой эмгэгүүд, нойрны эмгэг, архаг ядаргаа, тайлбарлах боломжгүй бие маходийн зовиур зэргийн үед өгөх зөвлөгөө

#### **Тойролт 2. Уушгини бус сүрьеэ**

- Яс ба үений сүрьеэ шалтгаан, эмнэлзүйн, илрүүлэлт, оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо, урьдчилан сэргийлэлт
- Шээс бэлэг эрхтний сүрьеэ: шалтгаан, эмнэлзүйн, илрүүлэлт, оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо, урьдчилан сэргийлэлт
- Сүрьеэгийн гаралтай захын булчирхайн гэмтэл: шалтгаан, эмнэлзүйн, илрүүлэлт, оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо, урьдчилан сэргийлэлт
- Гэдэс хэвлийн гялтан, чацаархайн тунгалагийн булчирхайн сүрьеэ шалтгаан, эмнэлзүйн, илрүүлэлт, оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо, урьдчилан сэргийлэлт
- Арьс ба арьсан доорх эслэгийн сүрьеэ: шалтгаан, эмнэлзүйн, илрүүлэлт, оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо, урьдчилан сэргийлэлт
- Нүдний сүрьеэ шалтгаан, эмнэлзүйн, илрүүлэлт, оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо, урьдчилан сэргийлэлт

#### **Тойролт 3. Хүүхдийн сүрьеэ**

- Анхдагч сүрьеэгийн шалтгаан, эмнэлзүй, илрүүлэлт, оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт
- Бронхаденитийн шалтгаан, эмнэлзүй, илрүүлэлт, оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо
- Далд сүрьеэгийн оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо, урьдчилан сэргийлэлт
- Нянсудлалаар батлагдсан уушгини сүрьеэгийн шалтгаан, эмнэлзүй, илрүүлэлт, оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо
- Лимфаденит: эмнэлзүй, илрүүлэлт, оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо

#### **Тойролт 4. Сүрьеэгийн хяналт, тандалт, сэргийлэлт, нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө**

- Сүрьеэгийн тохиолдлын илрүүлэлт: идэвхтэй, идэвхгүй илрүүлэлт, эрсдэлт бүлгийн сонгох арга, илрүүлэлт хийх зарчим, мөрдөх алгоритм; тохиолдлын бүртгэл
- Бүртгэл тайлан, цахим болон цаасан бүртгэл;
- Анхан шатны маягтын хөтлөлт;

- Сар улирал, жилийн тайлан гаргалт;
- Сүрьеэгийн тархвар судлал;
- Хавьтад судлал;
- Эмнэлзүй, ангилал;
- Дэгдэлтийг илрүүлэх;
- Дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээ;
- Халдварт хяналтын аргууд;
- Анхан шатны тусламж үйлчилгээний уялдаа холбоо;
- Туберкулины сорил, бусад шинжилгээний аргууд;
- Ухуулга нөлөөлөл, сургалт сурталчилгаа;
- Сүрьеэтэй өвчтөнд өгөх нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө

#### **Тойролт 5. Сүрьеэгийн лабораторийн болон радиологийн оношилгоо**

- Радиологи шинжилгээнд өвчтөнг бэлдэх;
- Цээжний гэрлийн шинжилгээ уншилт;
- Томографийн шинжилгээ хариу уншилт;
- MRI шинжилгээ, үр дүнг уншилт;
- Хиймэл оюун ухаан ашиглалт
- Сүрьеэтэй тэмцэх хөтөлбөрт лабораторийн гүйцэтгэх үүрэг, цахим бүртгэл, анхдагч хяналт алдагдалт;
- Лабораторийн шинжилгээний сорьц цуглуулалт, хадгалалт, илгээлт;
- Түрхэцийн шинжилгээний арга: түрхэц бэлдэх, будах, унших;
- Gene Xpert шинжилгээ, техник, хариу уншилт;
- Өсгөвөрлөх шинжилгээний аргууд: хатуу, шингэн тэжээлт орчин;
- Эмэнд тэсвэржилт тодорхойлох LPA(line probe assay) шинжилгээ;
- Хатуу, шингэн тэжээлт орчинд эмэнд мэдрэг чанар тодорхойлох
- Бүрэн геномын дараалал тогтоо шинжилгээ практик хэрэглээ;

#### **Тойролт 6. Яаралтай тусламж, сүрьеэз өвчний үеийн эгзэгтэй байдал**

- Эмнэлгийн яаралтай тусламжийн онол арга зүйн үндэс, эрэмбэлэн ялгалт;
- Амигуулах суурь тусламж: ухаангуй өвчтөнг үнэлэх; аюул ослыг зайлцуулах; цээж шахалт хийх; амьсгалын зам чөлөөлөх энгийн арга;
- Амьсгал, зүрх судас зогсох үндсэн шалтгаануудыг ирүүлэх;
- Амьсгалын замын бөглөрлийн яаралтай тусламж;
- Эрчимт эмчилгээнд ашиглагдах бичиг баримт хөтлөлт;
- Хүнд өвчтөний хяналт үнэлгээ;
- Амьсгалын дутагдалын үеийн эрчимт эмчилгээ;
- Зүрх судасны тогтолцооны эрчимт эмчилгээний тусламж;
- Хүчилтөрөгч эмчилгээний физиологийн үндэс, эмчилгээний зарчим;
- Амьсгалын аппаратын үйл ажиллагаа, төрөл, хэрхэн ашиглах;
- Шоктой өвчтөнд үзүүлэх яаралтай тусламж;

#### **Тойролт 7. Хавдар**

- Уушгины хорт хавдар шалтгаан, эмнэлзүй, оношилгоо, эмчилгээ, сүрьеэгийн ялган оношилгоо
- Төв мэдрэлийн тогтолцоо, тархи, нүдний хорт хавдар шалтгаан, эмнэлзүйн, оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо
- Тунгалагийн булчирхайн хорт хавдар эмнэлзүй, оношилгоо, эмчилгээ, сүрьеэгийн ялган оношилгоо
- Арьсны хорт хавдар эмнэлзүйн, оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо

#### **Тойролт 8. Дотрын өвчин**

- Уушгины хатгаа: эмнэлзүйн, оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо
- Уушгины архаг бөглөрөлт өвчин: эмнэлзүйн, оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо
- Ходоодны архаг үрэвсэл: эмнэлзүйн, оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо
- Элэгний хатуурал: эмнэлзүйн, оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо
- Чихрийн шижин : эмнэлзүйн, оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо
- Бөөрний архаг дутагдал : шалтгаан, эмнэлзүйн, оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо
- Зүрхний архаг дутагдал эмнэлзүйн, оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо
- Элэгний архаг дутагдал : шалтгаан, эмнэлзүйн, оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо
- Амьсгалын архаг дутагдал: эмнэлзүйн, оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо

#### **Тойролт 9. Сүрьеэгийн үеийн нөхөн сэргээх эмчилгээ**

- Уушгины сүрьеэгийн үеийн нөхөн сэргээх эмчилгээ
- Уушгины хагалгааны дараах нөхөн сэргээх эмчилгээ
- Нурууны сүрьеэгийн хагалгааны дараах нөхөн сэргээх эмчилгээ
- Яс үений хагалгааны дараах нөхөн сэргээх эмчилгээ
- Нөхөн сэргээх эмчилгээ: Мэдрэл булчингийн эмгэгүүд , үений гэмтэл, зөвлөн эдийн эмгэгүүдийн үеийн хөдөлгөөн засал эмчилгээ

#### **5.2.3. Зайлшгүй танин мэдэж, суралцах шаардлагатай гардан хийх үйлдэл (*Hands on clinical rotation schedule*)**

1. Үйлчлүүлэгчдийг эрэмбэлэн ангилалт, өвчтөнд хүлээн авах, бичиг баримтыг бүрдүүлэх, тусламж үзүүлэх,
2. Цээжний хөндийн хатгалт хийх /Thoracentesis – 34.91/
3. Хэвлийн хөндийд хатгалт хийж шингэнийг авах
4. Ходоодонд зонд тавих, угаах, цөс хаймсуурдах/Replacement of (nose-)gastric or esophagostomy tube – 97.01/
5. Амьсгалын замыг чөлөөлөх Non operative intubation of gastrointestinal and respiratory tracts – 96.0/
6. Амьсгалуулах хэрэгслүүдтэй ажиллах, амьсгал өгөх //Nontechnical methods of resuscitation – 93.93/

7. Нугасны хатгалт хийх
8. Гуурсан хоолой дурандах шинжилгээнд өвчтөнг бэлтгэх
9. Булчирхайнд хатгалт хийх
10. Өвчтөнг мэс засалд бэлтгэх
11. Цусны бүлэг тодорхойлж, унших
12. Судсаар эмчилгээг 24 цагийн турш хийх тооцоолол хийх, судсандаа гуурс тавих,
13. Амь тэнссэн өвчтөнд анхдагч үнэлгээ хийх, тусlamж үзүүлэх
14. Амилуулах суурь тусlamж үзүүлэх /Cardiopulmonary resuscitation, not otherwise specified – 99.60/
15. Эмнэлзүйн зөвлөлгөөнд өвчтөний асуудал хэлэлцүүлэх
16. Цус алдалтын үед тусlamж үзүүлэх
17. Түрхэцийн шинжилгээний түрхэц бэлдэх, будах
18. Түрхэц унших, чанарын хяналтын түрхэц сонгох аргыг эзэмших
19. Хувийн хамгаалах хэрэгсэл өмсөх, тайлах дадлага хийх
20. Халдвартын голомтонд тархварзүйн судалгаа хийх
21. Тусгай шүүгчтэй амны хаалтын тохироо шалгах сорил,
22. Агааржуулалт шалгах утаат сорил, агаарын чиглэл хөдөлгөөн шалгах аппарат тоног төхөөрөмжийг ажиллуулах
23. Захын цусанд глюкоз тодорхойлох
24. Хүнд өвчтөнг эмнэлэг дотор болон тээврийн хэрэгслээр аюулгүй зөөвөрлөх
25. Өвчтөнг тусгаарлах / Isolation – 99.84/
26. Нуруу нугасны гэмтэлтэй өвчтөнд бэхэлгээ хийх /Replacement of other cast – 97.13/

### Загвар 1

#### Ажлын байрны сургалт (On the job training)

Аргачлал	Суралцаг ч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч, хэрэглэгдэхүүн	Удирдаг, хамтрагч
Ганцаарчилсан үзлэг, тойролтын хуваарийн дагуу	1	Ажлын 3 цаг, өдөр бүр	Эмнэлгийн тасаг, амбулатори	Өвчтөн	Сургагч багш
Хяналтын тойрон үзлэг	3-5	1 цаг, өдөр бүр	Эмнэлгийн тасаг, амбулатори	Өвчтөн	Сургагч багш
Сургалтын тойрон үзлэг	20 хүртэл	2 цаг, 14 хоногт 1 удаа	Эмнэлгийн тасаг, амбулатори	Өвчтөн	Сургагч багш
Зөвлөх үзлэг	1	Тохиолдол байгаа үед	Эмнэлгийн тасаг, амбулатори	Өвчтөн	Сургагч багш
Гардан үйлдэл хийх	1	Тохиолдол байгаа үед	Эмнэлгийн тасаг, амбулатори	Өвчтөн	Сургагч багш

**Их эмчийн үзлэг, тойролтын хувиарын дагуу:** Суралцагч өдөр бүр тойролтын хувиарын дагуу 3-5 өвчтөнд их эмчийн үзлэг хийж оношийг тогтоож, эмчилгээг

төлөвлөж, зөвлөгөө өгнө. Тохиолдол бүрийн үзлэгийн үр дүнг эмнэлзүйн сургагч багшид хянуулна.

**Хяналтын тойрон үзлэг:** Суралцагч эмнэлзүйн сургагч багшид бусад суралцагчийн хамт өдөр бүрийн үзлэгийн үр дүнг танилцуулж, эмнэлзүйн сургагч багшийн хяналтын тойрон үзлэгт оролцно

**Сургалтын тойрон үзлэг:** Тойролт хийж буй тасагт хэвтэн эмчлүүлж байгаа 1 тохиолдлыг сонгон авч эмнэлзүйн сургагч болон бусад суралцагчдад танилцуулж онолын мэдлэг хуваалцах хэлэлцүүлэг хийнэ.

